



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/518

Улаанбаатар хот

Тушаал, тушаалын хавсралтад нэмэлт,
еөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дугаар хэсэг, 2017 оны 344 дүгээр тогтоолын 1 дүгээр хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/422 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний хөтөлбөр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт”-ийг хавсралтаар баталсугай.

2. Журмын 3.1.2. Тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд 3.1.2.6. Хүний нөөцийн удирдлага, хөгжил:нэмэлт оруулсугай: 3.1.2.6.1. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулах төлөвлөгөөний хэрэгжилт; 3.1.2.6.2. Төгсөлтийн дараах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн; 3.1.2.6.3. Байгууллагын ажилтны хүний нөөц бүрдүүлэлт, нөөцөөс авсан ажилтны тоо; 3.1.2.6.4. Албан тушаалын тодорхойлолт; 3.1.2.6.5. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг сайжруулах, ажлын байрны дэмжлэгт орчин бүрдүүлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн; 3.1.2.6.6. Ажлын байран дээрх осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, ажиллагсдыг урьдчилан сэргийлэх үзлэгт, эрүүл мэндийн ажилтныг дархлаажуулалтад хамруулсан байдал. Журмын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт”-ийн Нэг. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хүснэгтэд “45. Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан өрх, сумын эмч, сувилагч, тусгай мэргэжилтний хувь (20 хувиас доошгүй), 46. Шинээр ажилд авсан сувилагчийн тоо; 47. Нийгмийн хамгааллын чиглэлээр шинээр санаачилсан үйл ажиллагаа (тоо); 48. Орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхийг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ; Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв хүснэгтийн 2.1. Нийтлэг үзүүлэлтэд 19. Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан сувилагч, тусгай мэргэжилтний хувь (20 хувиас доошгүй), 20. Шинээр ажилд авсан сувилагчийн тоо; 21. Нийгмийн хамгааллын чиглэлээр шинээр санаачилсан үйл ажиллагаа (тоо)”. Журмын 9 дүгээр хавсралтаар баталсан

081995

“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт”-ийн Гурав. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар: 1. Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын өсөлт (хувь); 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, төвлөрүүлэлт, хуваарилалт (төгрөг); 3. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлагын гүйцэтгэл; 4. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, түүний хүүгийн орлогын хэмжээ (хувь, төгрөг); 5. Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөрийн актын барагдуулалтын хувь; 6. Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлсэн дундаж хугацаа; 7. 21 аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгтэй байгуулсан худалдан авах гэрээгээр эрүүл мэндийн даатгалын байгууллагын үүргийн биелэлтийн дундаж оноо; 8. Даатгуулагчийн сэтгэл ханамжийн хувь гэж тус тус нэмсүгэй.

3. Журмын 3.1.1.1. дэх хэсгийн “Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч (Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ерөнхий захирал)” гэснийг “Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч (Аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв); Журмын 7.11. “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын Үр дүнгийн гэрээг дүгнэхдээ Аймаг, нийслэлийн Засаг даргаас Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээг дүгнэсэн үнэлгээг үндэслэнэ” гэснийг “Төсвийн ерөнхийлөн захирагч Эрүүл мэндийн сайдаас төсвийн шууд захирагч Аймаг, нийслэлийн Засаг даргатай тухайн онд байгуулсан хамтран ажиллах гэрээ”; Журмын 7 дугаар хавсралтаар баталсан “Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг тайлагнах хүснэгт”-ийн 1.Хүний нөөцийг чадавхжуулах зорилтын 1.Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалтын үйл ажиллагааны Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг 3-5 хувь болгох; Журмын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт”-ийн Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв хүснэгтийн 2.1. Нийтлэг үзүүлэлтийн 14. Хүн амд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны хэлбэр, тоо гэж тус тус өөрчилсүгэй.

4. Журмын 9 дүгээр хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт”-ийн Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв хүснэгтийн 2.1. Нийтлэг үзүүлэлтийн “16. Эрүүл мэндийн байгууллагын ажиллагсдын үзлэгт хамрагдсан хувь”; 2.2. Өвөрмөц үзүүлэлтийн Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2. Тухайн жилд төлөвлөгдсөн тандалтын гүйцэтгэлийн хувь, 5. Лабораторийн оношийг баталгаажуулсан хувь, 9. Зоонозын халдварт өвчний дуудлагад цаг хугацаандаа үйлчилсэн байдал; 11. Эерэг сорьцын баталгаажилт; 12. Захиалгат тэжээлт орчин, биобэлдмэл, будаг, урвалжийн нийлүүлэлт; Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2. Шинээр хийгдсэн биобэлдмэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний тоо гэсэн шалгуур үзүүлэлтийг тус тус хассугай.

5. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/422 дугаар тушаалын журмын зургаадугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 2 дугаар сарын 11 өдрийн
4/578 дугаар тушаалын хавсралт

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(... оны жилийн эцсийн байдлаар)

№	Үндэсний хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1.	Үндэсний хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Үндэсний хөтөлбөрийн зорилго			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Зорилт 1. Зорилт 2. Зорилт 3 г.м.			
4.	Үндэсний хөтөлбөрийн зорилтууд	Үйл ажиллагааны хэрэгжилтийг доорх талбарт бичнэ.			
5.	Үндэсний хөтөлбөрийн зорилт:	1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнана Тайлбар: үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн бүх зорилтын хүрээнд тухайн ... онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа тус бүрээр тайлагнана (Засгийн газрын тогтоол буюу Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу)			
6.	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжилт	Зарцуулсан төсөв (улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламж, г.м.)
1					
2					
3					
4					
7.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Үүнд:			

		Багц 1							
		Багц 2 (г.м)							
8	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдсон ололтой тал, дутагдалтай талуудыг бичнэ.							
9	Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.							
10	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3			
		... %		... %	... %	... %			
11	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %							

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(...оны жилийн эцсийн байдлаар)

№	Төсөл, хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана)	Төсөл, хөтөлбөрийн зорилго
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Зорилт 2.
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)
		Үүнд: Төсөв (он) Гүйцэтгэл Хувь

